



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/387

Мандалговь

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг уул уурхайн салбарт зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 30.1.2 дах заалт, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 1/2936 тоот улсын үзлэг зохион байгуулах тухай удирдамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг уул уурхайн салбарт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ж.Мөнхчулуун (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Хишигдаваа (Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын дарга)
Р.Лхагвадорж (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
П.Нямсүрэн (Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч)
И.Тогооч (Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч)
Э.Цэвэлмаа (Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)
Б.Мөнхчулуун (Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)
Ж.Зоригтбаатар (Аймгийн ажил олгогч эздийн холбооны дарга)
О.Цэнгэлмаа (Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүлэгч)

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг уул уурхайн салбарт 2019 оны 10 сарын 28-наас 11 сарын 8-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн дарга болон гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191106